



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/351

Хэрлэн сум

Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 06 дугаар, 2022 оны Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай 08 дугаар, 2024 оны Аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засаг дарга дансны Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Зардлын тооцоо

№	Хийх ажил	Хугацаа	Хамрах хүрээ	Төсөв ₮
1	Эко клубын сурагчдын дунд хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил зохион байгуулж чадавхжуулах уралдаан зарлах /Хүүхдэд хүүхдээр дамжуулан нөлөөллийн ажил зохион байгуулна/	9 сар	Аймгийн ЕБ-ын бүх сургууль сурагчид хамрагдана	3,000,000
2	Хог хаягдал ангилан ялгах, дахин ашиглах шторк /Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар/	7 сар	Аймгийн хэмжээнд	500,000
3	Дахивар хог хаягдал авах цэгүүдийг сурталчлах	7 сар	Аймгийн хэмжээнд	500,000
4	Хог хаягдлын тухай хууль сурталчилах /Иргэн, ААНБ-ын үүрэг/	6 сар	Аймгийн хэмжээнд	500,000
5	Хог хаягдлын менежмент хэрэгжүүлж байгаа сайн туршлага сурталчилах	10 сар	Аймгийн хэмжээнд	500,000
Нийт				5,000,000